



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/76

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Арвандолдугаар жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх харагчин туулай жилийн хаврын тэргүүн бар сарын шинийн нэгний баярыг тохиолдуулан хавсралтад дурдсан 90-99 настай нэр бүхий 163 ахмад настанд гардуулах гарын бэлгэнд 8,150,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 8,150,000 (найман сая нэг зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс дарга (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0162